



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2014 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 22

Жаргалант

Г Тусгай хэрэгцээнд авах газрын хэмжээ, Г  
солбилцол тогтоох тухай

Жаргалант сумын Мандалын Бөөрөгт бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлоход газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр “Байдрагийн хөгжил” ТББ-ын хүсэлт, тухайн газрыг цэг, кординатыг хэлэлцүүлэхээр Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн саналыг хэлэлцээд Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанас ТОГТООХ нь:

Нэг. Жаргалант сумын Мандалын Бөөрөгт бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар солбилцлыг тогтоосон 12,1 га газрыг тусгай хэрэгцээнд тодорхой хугацаагүйгээр авсугай.

Хоёр. Дээрх тусгай хэрэгцээнд авсан газрын га-г тогтоож бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох эсэх дүгнэлтийг Ашигт малтмалын газар, Уул уурхайн хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлэн хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Далхаа нарт үүрэг болгосугай.

Гурав. Тусгай хэрэгцээнд авсан газрын солбилцол, талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513145

togtool -2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 23

Жаргалант

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Ойн тухай хуулийн 18.1.8-д заасныг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж шаардагдах хөрөнгө удирдлагаар хангаж ажиллахыг Засаг дарга Д.Сайнбилэг, Байгаль орчны албанд даалгасугай.


ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513147

togtool-2014

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014  
оны 23 дугаар тогтоолын хавсралт



**ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1	Ойн тухай хууль,гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах,гарын авлага бэлтгэн тараах	Түймрийн аюултай үед	Баг бүрт 15-с доошгүй хэвлэн тараах,иргэд суурь мэдлэгтэй болно.	Багийн Засаг дарга,байгаль хамгаалагч,байгууллагын дарга эрхлэгч нар
2	Ой, хээрийн түймрийн үед болон галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган хариуцах эздэд нэг бүрчлэн танилцуулж мөрдөж ажиллах.	04 дүгээр сар	Байгуулага бүр ажлын төлөвлөгөө гаргаж хариуцсан эздэд танилцуулсан байх	Багийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дарга эрхлэгч нар
3	Ой, хээрийн түймрээс сэргийлэх сэрэмжлүүлэг гарын авлага гарган багийн өрхүүдэд тараан сурталчлах	Түймрийн аюултай үед	Иргэдийн анхаарал, сэрэмж дээшлэнэ.	Байгаль хамгаалагч нар
4	Сумын орон тооны бус штабын төлөвлөгөөнд тодотгол хийж гал түймэр,гамшгийн үед ажиллах хүн,хүч, техник, багаж хэрэгслэлийн судалгааг гаргаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах	04 дүгээр сард	Улирал бүр бэлэн байдлыг шалгаж хэвших.	ЗДТГ-ын дарга
5	Ой, хээрийн түймэртэй тэмцэх ажилд иргэд, идэвхтэн байгаль хамгаалагч нарыг татан оролцуулж морин эргүүл гарган ажиллуулж тэдгээрийг ажиллах арга барил удирлагаар хангаж холбоо барих,мэдээлэл авах утас,тогтсон цагтай болох.	Байнга	Шаардлагатай мэдээ, мэдээлэлийг хүлээн авах утасны жагсаалтыг гаргах	Цагдаагийн хэсэг Багийн Засаг дарга Байгаль хамгаалагч
6	Багийн айл өрхүүдийн гэр байшин,малын хашаа,саравч, өвс тэжээлийн хашаа, худгийн эргэн тойронд шороон зурвас татах хот айлуудыг үнс нурмаа асгах нэгдсэн цэгтэй болгох	Байнга	Иргэдийн гэр хашаа,эд хөрөнгө хамгаалагдана.	Багийн Засаг дарга нар

7	Айл өрх бүрийг гал түймэр унтраах багаж хэрэгсэлтэй болгох	04 дүгээр сард	Бэлэн байдал хангагдана.	Багийн Засаг дарга нар
8	Аж ахуйн нэгж, албан байгууллагуудын галын аюулгүй байдал, гал командын бүрэн бүтэн байдлыг шалгах	04 дүгээр сард	Бэлэн байдал хангагдана	ЗДТГ-ын дарга
9	Зарлан мэдээлэлийн дуут дохиогоор иргэдийг цуглуулах сургуулалт хийх	05 дугаар сар	Мэргэжлийн ангиуд дадлагажина.	ЗДТГ-ын дарга
10	Ойн сан бүхий газар буюу өвс ургамал ихтэй газар машин техникийн янданг оч баригчтай байлгах анхаарулга санамж өгөх	Байнга	үзлэг шалгалтыг байнга хийж хэвшүүлэх.	Цагдаагийн хэсэг
11	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын талаар аймгийн байгаль орчны газарт өдөр бүр мэдээлж байх хувиарыг батлуулж мөрдөх.	2014.04.01- 2014.06.20. 2014.09.20- 2014.11.10- ны өдөр хүртэл	Байнгй мэдээлэлтэй байна.	БОХУБ, Байгаль хамгаалагч нар

\_\_\_\_\_ оО о \_\_\_\_\_



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 24

Жаргалант

Өмч хамгаалах зөвлөл байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дугаар зүйлийн 18.1.3-ын "Л", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийг өмчийн эд хөрөнгийг хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх эрх бүхий өмч хамгаалах зөвлөлийг шинчлэн доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Ганжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ш.Оюунцэцэг (Төрийн сангийн мэргэжилтэн)

(Тамгын газрын дарга)

Ж.Туяа (Нийгмийн даатгалын байцаагч)


Д.Мөнхжаргал (Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч)

Я.Дэнсмаа (Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч)

М.Нарантогтох (Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч)

Хоёр. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтанд хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллахыг Сумын Засаг дарга, өмч хамгаалах зөвлөлд даалгасугай.

Гурав. 2012 оны 4 дугаар сарын 25-ний өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 14-р тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР

1513150

togtool-2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 25

Жаргалант

Шинжлэх Ухааны зориулалтаар ан амьтан

агнах тухай

Жаргалант суманд Орон нутаг судлах танхимын баяжилт, төрөл зүйлийг нэмэгдүүлж халиун буга-1, согоо-1-ийг судалгаа, Ш.У-ны танин мэдэхүйн зориулалтаар агнаж мэргэжлийн байгууллагаар стандарт шаардлага хангасан “Чихмэл”-ийг хийлгье гэсэн Засаг дарга, БОУХ-ын байцаагчийн хүсэлтийг авч хэлэлцээд Амьтны тухай хуулийн 5.6 дах заалт, Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.12-ийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Судалгаа. Ш.У-ны зориулалтаар Халиун буга, согоо тус тус нэг ширхэгийг агнах зөвшөөрөл олгохыг Дээд шатны хурал болон байгаль орчин хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжилсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаар хяналт тавьж ажиллахыг Сумын засаг дарга Д.Сайнбилэг, 3

БОУХУ-ын байцаагч Д.Далхаа нарт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513153

togtool-2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 28 өдөр


Дугаар 26

Жаргалант

Төрийн дээд шагналд тодорхойлох  
тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай  
хуулийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус сум дахь Цагдаагийн хэсгийн хүсэлт, хамт олны тодорхойлолтыг  
үндэслэн жолооч Бизьяа овогтой Төрбатыг Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн  
хүндэт медаль"- иар шагнуулахаар Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг  
дарга нарт уламжилсугай.

ДАРГА  Д. ГАНТӨМӨР



1513156



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 27

Жаргалант

Төрийн дээд шагналд тодорхойлох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол улсад Ус цаг уурын алба үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан тус сумын Ус цаг уурын албанд олон жил үр бүтээлтэй ажилласан байгаль орчин ус цаг уурын тэргүүний ажилтан Тогтохоо овогтой Пүрэвжав, Рэнцэн овогтой Аръяамангал, Чойжилу овогтой Наранхүү нарыг байгууллага хамт олны тодорхойлолтыг үндэслэн Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнуулахаар Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нарт уламжилсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513160





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 218

Жаргалант

Ажлын хэсэг томилох  
Тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.12 дахь заалт, Сумын Засаг Даргын Тамгын газрын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Эрдэнэ вангийн хийдийн эд хөрөнгийг тоолж бүртгэн хамгаалалтанд авах, сэргээн засварлах хандивын ажиллагааг зохион байгуулах журам гаргаж мөрдөн ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга Д.Сайнбилэг, ажлын хэсгийн ахлагч С.Элбэгсайхан нарт даалгасугай.


ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513165

togtool-2014

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014  
оны 28 дугаар тогтоолын хавсралт



ЭРДЭНЭ ВАНГИЙН ХИЙДИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ТООЛЖ БҮРТГЭН  
ХАМГААЛАЛТАНД АВАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХАНДИВЫН АЖИЛЛАГААГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагчаар:	С.Элбэгсайхан
Гишүүдэд:	Б.Өнөрбаяр
	Д.Амартүвшин
	Ж.Уранчимэг
	Н.Өнөртүвшин
	Ч.Баттулга
	Б.Санжаасүрэн



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 30


Жаргалант

Иргэдийн төлөөлөгчдын хуралдааны  
тов зарлан хуралдуулах тухай

Мандалын Анагт Баянхонгор аймгийн нөхөн сэргээлтийн компани оруулж ажиллуулах тухай сумын олон талт зөвлөлийн шийдвэр, Тус сумын нэр бүхий залуучуудаас сумын Засаг даргатай холбоотой асуудлаар оруулж ирсэн санал зэргийг авч хэлэлцээд Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Жаргалант сумын ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 2014.06.22-ний өдрийн 12 цагт хуралдуулсугай.

Хоёр. Ээлжит бус хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллахыг ИТХ-ын ажлын албанд даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513181



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 31


Жаргалант

Иргэдийг нөхөн даатгалын шимтгэлийг  
төлүүлэх тухай

Засаг Захиргаа Нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ажилласан жил, тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны 04-р сарын 25-ний өдрийн албан даалгавар, багийн засаг даргын тодорхойлолтыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Жаргалант сумын ажилласан жилээ тооцуулсан нэн ядуу амьдралтай, орлогогүй, шимтгэлээ төлөх боломжгүй 1-р багийн 9 иргэн, 2-р багийн 7 иргэн, 3-р багийн 12 иргэн, 4-р багийн 4 иргэний нийтдээ 32 иргэдийн төлөх шимтгэлийн 2499840 төгрөгийг төлөхд түр ажлын байр гаргах санал тавих, улс, аймаг, сумын аврага малчид, төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт даалгах замаар Нийгмийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлэхийг сум, багийн засаг дарга, нийгмийн даатгалын байцаагч Ж.Туяа нарт даалгасугай.


Хоёр. Шимтгэл төлөгдөх иргэдийн нэрсийг тогтоолд хавсаргав.

ДАРГА  ДАНТӨМӨР



1516171

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014  
оны 31 дүгээр тогтоолын хавсралт



НӨХӨН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ  
ТӨЛҮҮЛЭХ ИРГЭДИЙН НЭРС

- 1-р Баг: Д.Болормаа  
Д.Сайнжаргал  
Г.Хүрэлбат  
Ш.Даваадорж  
Д.Баясгалан  
Г.Хүрэлсүх  
Н.Дарьсүрэн  
Н.Ганболд  
Г.Алтанцэцэг
- 2-р Баг: Б.Оюунчимэг  
Д.Ишдолгор  
Ч.Должинсүрэн  
Н.Ганбат  
Д.Хоролмаа  
Д.Энхтайван  
П.Дэцмаа
- 3-р Баг: О.Туяадэлгэр  
Д.Долгорсүрэн  
А.Батэрдэнэ  
В.Байдраг  
А.Оюунчимэг  
Д.Дашдулам  
Ш.Мижидсанж  
С.Дулмаа  
С.Адъяаахүү  
Ш.Энхбаяр  
Л.Мөнхбат  
О.Түвшинбаяр  
О.Батхүлэг
- 4-р Баг: Л.Тоов  
Д.Батболд  
Ц.Алтанцэцэг  
Д.Цэрэнпагма



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 32

Жаргалант

Баяр наадам зохион байгуулах хороо  
байгуулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга

Б.Өнөрбаяр /Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга

Ш.Ичинхорлоо /Дотоод ажил хариуцсан  
мэргэжилтэн/

Гишүүдэд

Н.Ганжаргал /Засаг даргын орлогч/

С.Элбэгсайхан /Цагдаагийн хэсгийн дарга/

Д.Пагмасүрэн /Нийгмийн хөгжлийн ажилтан/

Ш.Оюунцэцэг /Төрийн сангийн мэргэжилтэн/

М.Нарантогтох /Иргэний танхимын ажилтан/

Н.Өнөртүвшин /Соёлын төвийн эрхлэгч/

С.Оюун /Сургуулийн захирал/

Б.Батцэнгэл /Цэцэрлэгийн эрхлэгч/

Хоёр. Баяр наадмыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг баяр наадам зохион байгуулах хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд даалгасугай.


Гурав. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах салбар хороог хавсралтаар баталсугай.

ДАРГА



Д.ГАНТӨМӨР

1513173



ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

1. Хурдан морины комисс:

Дарга: М. Нарантогтох  
Гишүүдэд: Г. Бат-эрдэнэ  
М. Мөнхдалай  
Ч. Цэдэвсүрэн  
Ж. Должинсүрэн  
А. Лхагвадорж  
Г. Алтанхуяг  
С. Жаргалсайхан  
Ж. Туяа  
Ж. Сүхбаатар  
Т. Батэрдэнэ

2. Үндэсний бөхийн комисс:

Дарга: Д. Тайванжаргал  
Гишүүдэд: Н. Ганжаргал  
Д. Далхаа  
Б. Жанчивдорж  
Ш. Батбаатар

3. Үзэл суртлын комисс:

Дарга: Н. Өнөртүвшин  
Гишүүдэд: Д. Пагамсүрэн  
С. Оюун  
Г. Туяа  
Т. Алтаншагай  
Б. Батцэнгэл  
Г. Энхцэцэг

4. Хэв журмын комисс:

Дарга: С. Элбэгсайхан  
Гишүүдэд: М. Цэрэндаш  
Н. Аринболд  
А. Энхболд  
Б. Төрбат

5. Аж ахуйн комисс:

Дарга: Б. Санжаасүрэн  
Гишүүдэд: Ш. Оюунцэцэг  
Б. Уртнасан  
У. Буг-Очир  
Д. Уранчимэг  
Ц. Сарантуяа  
С. Цэнгэлмаа  
П. Пүрэвдорж  
Н. Эрдэнэ-Очир  
Д. Дашхүү  
О. Батмөнх



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 33

Жаргалант

Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга	Сумын Засаг дарга
Орлогч дарга	Сум дундын эмнэлгийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
Гишүүдэд	Нийгмийн хөгжлийн ажилтан
	Соёлын төвийн эрхлэгч
	Сургуулийн захирал
	Цэцэрлэгийн эрхлэгч
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Багийн Засаг дарга нар
	1, 2, 3 дугаар багийн хүний эмч

Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн төлөвлөгөөг эрчимжүүлж ажиллахыг салбар зөвлөлийн дарга Д.Сайнбилэгт даалгасугай.

Гурав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513175  
togtool-2014